

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/3/СТА-ТШЗ

Агуулга

1 Аудитын гэрчилгээ.....	2
2 Аудитын тайлан.....	4
2.1 Оршил	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.13 Өвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Шилэн дансны мэдээлэл	8
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3 Менежментийн захидал.....	10
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	22
5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил.....	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.07 № 06/400
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус төвийн захирал Ж.Чинбүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн худалдан авах ажиллагаа, бусад авлага, татаас санхүүжилтийн авлага, үндсэн хөрөнгө, авлагыг зардалд бүртгэсэн тухай, анхан шатны баримт, орлого үр дүнгийн тайлан, төвлөрүүлэн шилжүүлэг, жижиг мөнгөн сангийн талаар зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 23-наас 2019 оны 02 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Лайэн Аудит” ХХК-ийн аудитор Т.Бид-Ялав, П.Сайнцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/278 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хавдар судлалын үндэсний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ” гэж тодорхойлсны дагуу Хавдар судлалын үндэсний төв нь үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хорт хавдар өвчний тархалтын түвшинг тогтоох, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, оношлох
- Технологийн дэвшил, мэс заслын эмчилгээ,
- 24 цагийн лаборатори
- 21 аймаг, 9 дүүргийн хими туяа эмчилгээ.

Хавдар судлалын үндэсний төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хавдар судлалын үндэсний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
- Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журмаас Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт орсноос бусад хууль, тогтоомж, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус төв нь ерөнхий захирлын 170 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2015 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

Хавдар судлалын үндэсний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хавдар судлалын үндэсний төв санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Хавдар судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “хэвийн” байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хавдар судлалын үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 1 хувиар сонгов.

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны нийт зардал 24,269,080.3 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 242,690.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 8 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	5	174,369.6	
2	Албан шаардлага өгсөн	1	260,010.4	
	Дүн	6	434,380.0	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Тус байгууллага нь 2018 онд 260,010.4 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, өндөр өртөгтэй эмнэлгийн нэг удаагийн хэрэгсэл шууд худалдан авалт хийсэн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр тогтов.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад цалингийн талаар нарийвчлан судалж амжаагүй тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хавдар судлалын үндэсний төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 4 хөтөлбөр, 1 арга хэмжээнд зориулан 2018 онд 21,163,770.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 21,108,084.5 мянган төгрөг буюу 99.7 хувьтай 55,686.4 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Хавдар судлалын үндэсний төв шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудас www.shilendans.gov.mn сайтад 2018 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хагас жилийн санхүүгийн тайлан, 2019 оны төсвийн төсөл болон цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт 13,325,152.1 мянган төгрөгийн 815 ажил гүйлгээний мэдээллийг байршуулж олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгсний 3 зөвлөмжийг биелүүлж, биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 75 хувьтай байна. Өндөр өртөгт эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт хийхдээ өмнөх тендерийн гэрээг үргэлжлүүлэн хийсэн, шууд гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дугаар заалтыг зөрчсөн бөгөөд зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хавдар судлалын үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Бусад авлагын талаар:

3.1.1 Илрүүлэлт: Бест стандарт констракшн ХХК-тай 2018 оны 05 сарын 17-ны өдөр Химийн тасагт засварын ажлыг 1 сарын хугацаанд хийж гүйцэтгэх 79,600.0 мянган төгрөгийн гэрээг 1 сарын хугацаатай байгуулж 5 дугаар сарын 18-ны өдөр 60,000.0 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн боловч 2018 онд багтааж уг ажлыг хийж гүйцэтгээгүйгээс авлага үүссэн байна.

Энэ нь Тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулаагүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Авлага, өглөг үүсгэхгүй байх, төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, баталгаажуулсан.

3.2 Үндсэн хөрөнгийн талаар

3.2.1 Илрүүлэлт: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр 25,231.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” 6 дугаар зүйлийн 1.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1 дэхь заалтыг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл: Хууль, тогтоомж зөрчигдөх,

3.2.3 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмыг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, баталгаажуулсан.

3.3 Анхан шатны баримтын талаар

3.3.1 Илрүүлэлт: Си-Ай-Ти ХХК-тай засварын ажлын гэрээ байгуулаагүй байхад анхан шатны бүрдэл дутуу баримтаар 30,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 1.4 дэхь заалтыг тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл: Хууль, тогтоомж зөрчигдөх,

3.3.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, баталгаажуулсан.

3.4 Санхүүгийн үр дүнгийн тайлангийн талаар

3.4.1 Илрүүлэлт: Санхүүгийн үр дүнгийн тайланд 25,937.6 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг тусгалгүй орхигдуулан тайлагнасан.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэхь заалтыг тус тус зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл: Үр дүнгийн тайлан буруу илэрхийлэгдэх,

3.4.3 Өгсөн зөвлөмж: Орлогыг санхүүгийн тайланд бүрэн тусгах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, баталгаажуулсан.

3.5 Авлагыг зардлаар бүртгэсэн талаар

3.5.1 Илрүүлэлт: Эрүүл мэндийн сайдын 2018 оны 12 сарын 11-ний өдрийн "Гадаад сургалтын төлөвлөгөө, эрүүл мэндийн ажилтны нэр, сургалтын зардал батлах тухай" А/159 дүгээр тушаалын дагуу гадаад сургалтанд явах нэр бүхий 14 хүний томилолтын зардал 33,200.5 мянган төгрөгийг 12 сарын 24-нд олгосныг авлагаар бүртгэлгүй гадаад томилолтын зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

3.5.2 Эрсдэл: Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.5.3 Өгсөн зөвлөмж: Авлага, өглөгийг үүсгэхгүй байх, төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврыг мөрдөж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 7 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,731,489,949.28</u>	<u>2,175,683,784.17</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ		
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
АВЛАГА	46,138,909.74	113,538,900.00
Татаас, санхүүжилтийн авлага		53,538,900.00
Бусад авлага	46,138,909.74	60,000,000.00
Байгууллагаас авах авлага	46,138,909.74	60,000,000.00
УРЬДЧИЛГАА		
БАРАА МАТЕРИАЛ	1,685,351,039.54	2,062,144,884.17
Түүхий эд материал	923,195,613.32	842,937,130.49
Эм боох материал	923,195,613.32	842,937,130.49
Хангамжийн материал	762,155,426.22	1,219,207,753.68
Бичиг хэргийн материал	567,700.00	10,449,700.00
Аж ахуйн материал	26,924,000.00	26,924,000.00
Барилгын засварын материал	14,793,288.26	42,407,800.00
Хүнсний материал	27,938,648.90	14,353,196.30
Бусад хангамжийн материал	691,931,789.06	1,125,073,057.38
НӨӨЦИЙН БАРАА		
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>19,819,053,405.89</u>	<u>25,579,415,274.37</u>
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	19,819,053,405.89	25,579,415,274.37
Биет хөрөнгө	19,813,314,939.16	24,274,622,694.50
Барилга, байгууламж, орон сууц	18,742,045,687.10	17,901,182,207.00
Хуримтлагдсан элэгдэл	-7,612,853,628.95	-210,613,487.19
Авто-тээврийн хэрэгсэл	312,862,000.00	312,862,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-250,002,972.48	-286,894,639.20
Машин тоног төхөөрөмж (компьютер)	19,758,794,773.08	19,918,994,223.08
Хуримтлагдсан элэгдэл	-11,545,801,195.10	-13,742,846,916.82
Тавилга, аж ахуйн эд хогшил	731,452,778.69	786,139,688.69
Хуримтлагдсан элэгдэл	-403,431,543.86	-476,411,564.79
Бусад үндсэн хөрөнгө	246,741,594.31	247,024,912.31
Хуримтлагдсан элэгдэл	-166,492,553.63	-174,813,728.58
Биет бус хөрөнгө	5,738,466.73	1,304,792,579.87
Програм хангамж	202,171,939.00	202,171,939.00
Хуримтлагдсан элэгдэл	-196,433,472.27	-201,829,439.13
Бусад биет бус хөрөнгө		1,304,450,080.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>21,550,543,355.17</u>	<u>27,755,099,058.54</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>-</u>	<u>-</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>21,550,543,355.17</u>	<u>27,755,099,058.54</u>
Засгийн газрын хувь оролцоо	21,550,543,355.17	27,755,099,058.54
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	17,025,450,888.38	18,948,084,398.38
Өмч: - төрийн	17,025,450,888.38	18,948,084,398.38
- хувийн		
- хувьцаат		
Хуримтлагдсан үр дүн	-232,597,781.34	-2,196,617,329.23
Өмнөх үеийн үр дүн	-232,597,781.34	-232,597,781.34
Тайлант үеийн үр дүн		-1,964,019,547.89
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,757,690,248.13	11,003,631,989.39
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>21,550,543,355.17</u>	<u>27,755,099,058.54</u>

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	27,086,861,507.52	22,305,060,734.04
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,197,822,227.00	3,678,389,055.04
Нийтлэг татварын бус орлого	2,249,633,080.00	3,678,389,055.04
Төсөв байгууллагын өөрийн орлого	2,249,633,080.00	3,678,389,055.04
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,900,319,237.00	3,026,033,378.50
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	185,204,785.00	155,866,043.42
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	164,109,058.00	496,489,633.12
Тусламжийн орлого	5,948,189,147.00	
Хандив тусламж /дотоод/	5,948,189,147.00	
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18,889,039,280.52	18,626,671,679.00
Улсын төвлөрсөн төсвөөс	9,199,958,300.00	10,951,218,400.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,199,958,300.00	10,951,218,400.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	2,652,071,066.52	403,103,900.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	79,750,740.00	37,370,000.00
Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	54,493,126.52	55,445,575.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,111,667,200.00	80,800,098.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	406,160,000.00	229,488,227.00
Төсвийн захирагчдаас		297,392,750.00
Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт		297,392,750.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7,037,009,914.00	6,974,956,629.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,037,009,914.00	6,974,956,629.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,379,265,440.65	4,269,080,281.93
УРСГАЛ ЗАРДАЛ	21,379,265,440.65	24,269,080,281.93
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,830,159,417.33	24,061,708,247.82
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,812,081,307.00	6,664,902,869.27
Үндсэн цалин	5,807,757,307.00	3,575,468,762.00
Нэмэгдэл	456,000.00	1,763,223,228.27
Унаа хоолны хөнгөлөлт		419,853,600.00
Урамшуулал		906,357,279.00
Гэрээт ажлын хөлс	3,868,000.00	

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	696,164,697.05	865,683,805.78
Тэтгэврийн даатгал	413,024,742.05	537,479,516.00
Тэтгэмжийн даатгал	46,653,816.00	56,032,686.78
ҮОМШӨ-ний даатгал	113,652,371.00	131,543,627.00
Ажилгүйдлийн даатгал	11,163,288.00	12,747,509.00
Эрүүл мэндийн даатгал	111,670,480.00	127,880,467.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	437,126,774.00	424,613,112.02
Гэрэл, цахилгаан	201,660,593.00	202,773,962.00
Түлш, халаалт	120,339,117.00	117,435,562.00
Цэвэр, бохир ус	115,127,064.00	102,963,588.02
Байрны түрээс		1,440,000.00
Хангамж, бараа материалын зардал	321,471,006.00	422,835,953.91
Бичиг хэрэг	61,667,441.00	102,241,784.10
Тээвэр, шатахуун	34,417,331.00	22,604,205.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,279,479.00	17,993,308.81
Ном, хэвлэл		1,210,000.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21,672,000.00	21,624,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,646,400.00	290,708.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	192,138,890.00	256,871,948.00
Бараа материал акалсны зардал	649,465.00	
Нормативт зардал	6,028,511,275.61	9,947,004,939.98
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,635,199,615.71	9,511,558,621.38
Хоол, хүнс	393,311,659.90	435,446,318.60
Эд хогшил, урсгал засварын зардал	324,387,220.74	439,741,127.38
Багаж, техник, хэрэгсэл	7,357,452.00	5,783,775.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,135,000.00	1,103,815.00
Урсгал засвар	315,894,768.74	432,853,537.38
Томилолт, зочны зардал	29,394,500.00	84,192,000.00
Гадаад албан томилолт		58,200,500.00
Дотоод албан томилолт	29,394,500.00	25,991,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,638,311.20	84,815,506.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70,200,000.00	69,200,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		6,000,000.00
Даатгалын үйлчилгээ	305,660.00	346,500.00
Тээврийн хэрэгслийн татвар	396,000.00	941,100.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	84,100.00	143,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,681,251.20	2,953,182.00
Газрын төлбөр	3,652,000.00	2,431,704.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	319,300.00	2,800,020.00
Бараа үйлчилгээний бусад зардал	7,097,384,325.73	5,127,918,933.48
Бараа үйлчилгээний бусад зардал	4,360,272,941.68	2,418,157,654.80
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	82,046,551.00	86,661,535.90
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,655,064,833.05	2,623,099,742.78

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	549,106,023.32	207,372,034.11
Бусад урсгал шилжүүлэг	480,575,800.00	192,915,357.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,330,000.00	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	295,745,800.00	192,915,357.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	151,500,000.00	
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	68,530,223.32	14,456,677.11
Төвлөрүүлэх шилжүүлэг	68,530,223.32	14,456,677.11
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>5,707,596,066.87</u>	<u>-1,964,019,547.89</u>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	3,283.57	
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	3,283.57	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,810,133.57	
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,810,133.57	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-6,806,850.00	
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>5,700,789,216.87</u>	<u>(1,964,019,547.89)</u>

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>18,955,792,908.94</u>	<u>21,854,710,010.66</u>
ТАТВАРЫН ОРЛОГО		
Орлогын албан татвар		
Хувь хүний орлогын албан татвар		
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,093,252,865.00	3,181,899,421.92
Нийтлэг татварын бус орлого	2,093,252,865.00	3,181,899,421.92
Төсөв байгууллагын өөрийн орлого	2,093,252,865.00	3,181,899,421.92
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,897,302,800.00	3,026,033,378.50
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	195,950,065.00	155,866,043.42
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,862,540,043.94	18,672,810,588.74
Улсын төвлөрсөн төсвөөс	9,199,958,300.00	10,951,218,400.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,199,958,300.00	10,951,218,400.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	625,571,829.94	449,242,809.74
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	79,750,740.00	37,370,000.00
Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	54,493,126.52	55,445,575.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,467,200.00	126,939,007.74
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	481,860,763.42	229,488,227.00
Төсвийн захирагчдаас		297,392,750.00
Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт		297,392,750.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7,037,009,914.00	6,974,956,629.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,037,009,914.00	6,974,956,629.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>18,785,721,708.94</u>	<u>21,657,778,550.66</u>
УРСГАЛ ЗАРДАЛ	18,785,721,708.94	21,657,778,550.66
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,204,085,995.88	21,396,867,616.55
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,821,435,955.85	6,499,149,355.67
Үндсэн цалин	3,815,391,956.00	3,938,913,320.47
Нэмэгдэл	537,486,499.85	1,388,208,747.00
Унаа хоолны хөнгөлөлт	459,826,100.00	570,750,000.00
Урамшуулал	537,759,700.00	601,277,288.20
Гэрээт ажлын хөлс	470,971,700.00	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	687,981,500.00	820,068,800.00

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тэтгэврийн даатгал	687,981,500.00	504,657,800.00
Тэтгэмжийн даатгал		63,082,200.00
ҮОМШӨ-ний даатгал		113,548,000.00
Ажилгүйдлийн даатгал		12,616,400.00
Эрүүл мэндийн даатгал		126,164,400.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	437,126,774.00	424,613,112.02
Гэрэл, цахилгаан	201,660,593.00	202,773,962.00
Түлш, халаалт	120,339,117.00	117,435,562.00
Цэвэр, бохир ус	115,127,064.00	102,963,588.02
Байрны түрээс		1,440,000.00
Хангамж, бараа материалын зардал	229,851,360.00	301,741,707.81
Бичиг хэрэг	7,601,840.00	30,261,601.00
Тээвэр, шатахуун	34,630,331.00	21,934,205.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,319,479.00	18,033,308.81
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	139,279,710.00	201,623,735.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	39,020,000.00	29,888,858.00
Нормативт зардал	6,612,624,033.63	7,209,323,449.73
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,138,680,328.33	6,722,543,093.73
Хоол, хүнс	417,295,105.30	429,683,081.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	56,648,600.00	57,097,275.00
Эд хогшил, урсгал засварын зардал	177,586,361.00	567,428,876.32
Багаж, техник, хэрэгсэл	28,013,601.00	60,612,337.00
Тавилга	25,085,800.00	
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	13,741,110.00	11,992,515.00
Урсгал засвар	110,745,850.00	494,824,024.32
Томилолт, зочны зардал	29,424,500.00	84,352,000.00
Гадаад албан томилолт		58,200,500.00
Дотоод албан томилолт	29,424,500.00	26,151,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,507,911.20	103,704,104.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70,200,000.00	69,200,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		6,000,000.00
Даатгалын үйлчилгээ	305,660.00	346,500.00
Тээврийн хэрэгслийн татвар	396,000.00	941,100.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	84,100.00	143,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,005,251.20	3,188,000.00
Газрын төлбөр	3,652,000.00	2,431,704.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,864,900.00	21,453,800.00
Бараа үйлчилгээний бусад зардал	4,106,547,600.20	5,386,486,211.00
Бараа үйлчилгээний бусад зардал	4,019,242,589.20	5,284,434,083.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	87,305,011.00	102,052,128.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	581,635,713.06	260,910,934.11
Засгийн газрын урсгал шилжүүлэг	46,138,909.74	
Засгийн газрын дотоод шилжүүлэг	46,138,909.74	
Бусад урсгал шилжүүлэг	466,966,580.00	192,915,357.00

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	295,745,800.00	192,915,357.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	171,220,780.00	
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	68,530,223.32	67,995,577.11
Төвлөрүүлэх шилжүүлэг	68,530,223.32	67,995,577.11
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>170,071,200.00</u>	<u>196,931,460.00</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	170,071,200.00	196,931,460.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	170,071,200.00	196,931,460.00
Дотоод эх үүсвэрээр	170,071,200.00	196,931,460.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	170,071,200.00	196,931,460.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(170,071,200.00)</u>	<u>(196,931,460.00)</u>
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,025,450,888.38	4,759,387,968.04	-5,933,386,998.21	15,851,451,858.21
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,025,450,888.38	4,759,387,968.04	-5,933,386,998.21	15,851,451,858.21
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			5,700,789,216.87	5,700,789,216.87
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,025,450,888.38	4,757,690,248.13	-232,597,781.34	21,550,543,355.17
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,025,450,888.38	4,757,690,248.13	-232,597,781.34	21,550,543,355.17
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		6,245,941,741.26		6,245,941,741.26
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн	1,922,633,510.00		-1,964,019,547.89	-41,386,037.89
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	18,948,084,398.38	11,003,631,989.39	-2,196,617,329.23	27,755,099,058.54

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,163,770,900.00	21,108,084,450.92	55,686,449.08	99.74
УРСГАЛ ЗАРДАЛ	21,163,770,900.00	21,108,084,450.92	55,686,449.08	99.74
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,970,855,100.00	20,900,782,005.95	70,073,094.05	99.67
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,366,222,100.00	6,366,222,099.67	0.33	100.00
Үндсэн цалин	3,776,497,300.00	3,807,871,652.67	-31,374,352.67	100.83
Нэмэгдэл	1,419,583,100.00	1,388,208,747.00	31,374,353.00	97.79
Унаа хоолны хөнгөлөлт	570,750,000.00	570,750,000.00	0.00	100.00
Урамшуулал	599,391,700.00	599,391,700.00	0.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	820,068,800.00	820,068,800.00	0.00	100.00
Тэтгэврийн даатгал	504,657,800.00	504,657,800.00	0.00	100.00
Тэтгэмжийн даатгал	63,082,200.00	63,082,200.00	0.00	100.00
ҮОМШӨ-ний даатгал	113,548,000.00	113,548,000.00	0.00	100.00
Ажилгүйдлийн даатгал	12,616,400.00	12,616,400.00	0.00	100.00
Эрүүл мэндийн даатгал	126,164,400.00	126,164,400.00	0.00	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	424,074,800.00	423,173,112.02	901,687.98	99.79
Гэрэл, цахилгаан	203,271,900.00	202,773,962.00	497,938.00	99.76
Түлш, халаалт	117,827,400.00	117,435,562.00	391,838.00	99.67
Цэвэр, бохир ус	102,975,500.00	102,963,588.02	11,911.98	99.99
Хангамж, бараа материалын зардал	297,184,600.00	297,183,907.81	692.19	100.00
Бичиг хэрэг	25,913,400.00	26,901,301.00	-987,901.00	103.81
Тээвэр, шатахуун	17,850,000.00	21,296,705.00	-3,446,705.00	119.31
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,086,400.00	17,473,308.81	-4,386,908.81	133.52
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	213,985,400.00	201,623,735.00	12,361,665.00	94.22
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,349,400.00	29,888,858.00	-3,539,458.00	113.43
Нормативт зардал	6,968,937,600.00	6,963,923,037.13	5,014,562.87	99.93
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,484,409,400.00	6,495,742,681.13	-11,333,281.13	100.17
Хоол, хүнс	424,645,100.00	411,083,081.00	13,562,019.00	96.81
Нормын хувцас, зөөлөн эдлэл	59,883,100.00	57,097,275.00	2,785,825.00	95.35
Эд хогшил, урсгал засварын зардал	647,313,200.00	647,168,196.32	145,003.68	99.98
Багаж, техник, хэрэгсэл	66,038,800.00	108,292,827.00	-42,254,027.00	163.98

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,995,000.00	13,887,345.00	1,107,655.00	92.61
Урсгал засвар	566,279,400.00	524,988,024.32	41,291,375.68	92.71
Томилолт, зочны зардал	5,435,400.00	3,803,500.00	1,631,900.00	69.98
Дотоод албан томилолт	5,435,400.00	3,803,500.00	1,631,900.00	69.98
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,255,200.00	103,704,104.00	1,551,096.00	98.53
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,214,600.00	69,200,000.00	14,600.00	99.98
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.00
Даатгалын үйлчилгээ	346,500.00	346,500.00	0.00	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000.00	941,100.00	58,900.00	94.11
Тээврийн хэрэгслийн оношлогоо	84,100.00	143,000.00	-58,900.00	170.04
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,188,000.00	3,188,000.00	0.00	
Газрын төлбөр	3,960,000.00	2,431,704.00	1,528,296.00	61.41
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	21,462,000.00	21,453,800.00	8,200.00	99.96
Бараа үйлчилгээний бусад зардал	5,336,363,400.00	5,275,535,249.00	60,828,151.00	98.86
Бараа үйлчилгээний бусад зардал	5,336,363,400.00	5,275,535,249.00	60,828,151.00	98.86
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	192,915,800.00	207,302,444.97	-14,386,644.97	107.46
Бусад урсгал шилжүүлэг	192,915,800.00	192,915,357.00	443.00	100.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	192,915,800.00	192,915,357.00	443.00	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		0.00	0.00	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,163,770,900.00	21,108,084,450.92	55,686,449.08	99.74
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,391,218,400.00	10,951,218,400.00	440,000,000.00	96.14
Улсын төсвөөс санхүүжих	11,391,218,400.00	10,951,218,400.00	440,000,000.00	96.14
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,660,463,000.00	6,974,956,629.00	-314,493,629.00	104.72
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,660,463,000.00	6,974,956,629.00	-314,493,629.00	104.72
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,112,089,500.00	3,181,899,421.92	-69,809,921.92	102.24
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,892,089,500.00	3,026,033,378.50	-133,943,878.50	104.63
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	220,000,000.00	155,866,043.42	64,133,956.58	70.85
АЖИЛЛАГСАДЫН ТОО	563.00	563.00	0.00	
Гүйцэтгэх ажилтан	488.00	488.00	0.00	
Үйлчлэх ажилтан	75.00	75.00	0.00	

Огноо:

2019.02.25

Аудитын нэр:

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Аудитын код:

САГ-2019/3/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:

Хавдар судлалын үндэсний төв

Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Тус байгууллага нь 2018 онд 260,010.4 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, өндөр өртөгтэй эмнэлгийн нэг удаагийн хэрэгсэл шууд худалдан авалт хийсэн байна.	260.0	Албан шаардлага өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Ц.Энхээ
2	Бест стандарт констракшн ХХК-тай 2018 оны 05 сарын 17-ны өдөр Химийн тасагт засварын ажлыг 1 сарын хугацаанд хийж гүйцэтгэх 79,600.0 мянган төгрөгийн гэрээг 1 сарын хугацаатай байгуулж 5 дугаар сарын 18-ны өдөр 60,000.0 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн боловч 2018 онд багтааж уг ажлыг хийж гүйцэтгээгүйгээс авлага үүссэн байна.	60.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Ц.Энхээ
3	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр 25,231.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн байна.	25.2	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Ц.Энхээ
4	Си-Ай-Ти ХХК-тай засварын ажлын гэрээ байгуулахаасаа өмнө нэхэмжлэхийг нь аван түүнийг үндэслэн 30,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.	30.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Ц.Энхээ
5	Санхүүгийн үр дүнгийн тайланд 25,937.6 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг тусгалгүй орхигдуулан тайлагнасан.	25.9	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Ц.Энхээ

Хавдар судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	Эрүүл мэндийн сайдын 2018 оны 12 сарын 11-ний өдрийн "Гадаад сургалтын төлөвлөгөө, эрүүл мэндийн ажилтны нэр, сургалтын зардал батлах тухай" А/159 дүгээр тушаалын дагуу гадаад сургалтанд явах нэр бүхий 14 хүний томилолтын зардал 33,200.5 мянган төгрөгийг 12 сарын 24-нд олгосныг авлагаар бүртгэлгүй гадаад томилолтын зардлаар бүртгэсэн байна.	33.2	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Ц.Энхээ
	Дүн	434.4			

